

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын  
2018 оны ... дугаар сарын ... -ны өдрийн  
... дугаар тушаалын хавсралт

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ХЭЛТЭС, СУМ, ДҮҮРГИЙН  
МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИГЭЭНИЙ НЭГЖИЙН АЖЛЫГ ДҮГНЭЖ  
УРАМШУУЛАХ ЖУРАМ**

**Нэг. Зорилго**

1.1. Энэхүү журмын зорилго нь “Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай” хуулийн ..... заалтыг ханган биелүүлэх;

1.2. Мал эмнэлгийн асуудал эрхэлсэн төрийн Захиргааны төв байгуулалгын бүрэн эрхийн хүрээнд “Мал эмнэлгийн албыг бодлогын болон мэргэжил арга зүйн нэгдсэн удирдгаар хангаж, хамтран ажиллах”;

1.3. “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны ерөнхий шаардлага” MNS 5368 :2018 стандартыг хэрэгжүүлэх;

1.4. Мал эмнэлгийн анхан шат (хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж)-ын байгууллагын биеээ даасан байдлыг хангах, малын эмч нарын нийгмийн халамжийг баталгаажуулах, идэвх санаачилгыг хөхүүлэн дэмжиж замаар төр, хувийн хэвшлийг хөгжүүлэх;

1.5. Мал бүхий иргэд нэг бүрт төрийн захиалгат ажил, үйлчилгээ хүргэж үйлчлэн, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн баталгааг авах;

1.6. Эдгээр цогц үйлчилгээг хүргэснээр мал сүргийг эрүүлжүүлэх, тогтвортой өсөлтийг хангах, улмаар мал нь эрүүл өрх, баг, сум, аймгийн тоог жил дараалан нэмэгдүүлж, Монгол улс тухайн өвчнөөр тайван, эрүүл бүс нутаг болоход малын эмчийн оруулж буй хувь нэмрийг жил бүр үнэлж, дүгнэн урамшуулахад оршино.

**Хоёр. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, сумын мал эмнэлгийн тасаг,  
хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ажлыг дүгнэх үзүүлэлт**

**2.1. Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, сумын мал эмнэлгийн тасаг болон хувийн мал эмнэлгийн нэгжийн ажлыг дараах үндсэн үзүүлэлтээр дүгнэнэ. Үүнд:**

2.1.1. Халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл;

2.1.2. Паразит, халдваргүй өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, түүний гүйцэтгэл (паразит өвчний урьдчилан сэргийлэх угаалга, туулга, боловсруулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийн төлөвлөгөө, гүцэтгэл, оношлогоо, эмчилгээ) тус бүрийн үр дүн

2.1.3. Лабораторийн шинжилгээний төлөвлөгөө, гүйцэтгэл;

2.1.4. Графикт мэдээг цаг хугацаанд ирүүлсэн, (халдварт, гоц халдварт өвчний оношлогоо, эмчилгээ, үр дүн, гүйцэтгэлийн тайлан, бүрдүүлж ирүүлсэн материалын бүрдүүлэлт, эмх цэгц, шаардлага хангасан байдал, дараа оны захиалга, төлөвлөгөө ирүүлсэн байдал г.м)

**2.2. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, сумын Мал эмнэлгийн тасаг энэ журмын 2.1-д зааснаас гадна дор дүрдсэн нэмэлт үзүүлэлтээр дүгнэнэ: Үүнд:**

2.2.1 Мал эмнэлгийн холбогдолтой хөтөлбөрийн хэрэгжилт

- “Малын эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөр

- “Малын зарим архаг халдварт өвчинтэй тэмцэх хөтөлбөр
- “Адууны цус багадах өвчинтэй тэмцэх” хөтөлбөр
- “Үхрийн лейкоз өвчинтэй тэмцэх” хөтөлбөр
- “Үхэр, хонь, ямааны бруцеллёз болон үхрийн арьсны гууртах өвчинтэй тэмцэх”

дэд хөтөлбөр;

2.2.2. Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээн, тусгай захиалгат бүтээгдэхүүнийг хугацаанд нь 95-100 хувь биелүүлсэн байна;

2.2.3. Тухайн орон нутагт халдварт, паразит өвчний гаралтыг өмнөх 5-н жилийн дунджаас 5-10 хувиар бууруулсан, оношлогоо баталгаажсан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой, үр дүнтэй байна.

2.2.4. Байглийн голомтот халдварт өвчнүүдийн газар зүйн байршлыг GPS ашиглан байршил тогтоож зураглалд оруулж өвчин гарсан газрыг ариутгаж халдваргүйжүүлсэн, тэмдэгжүүлсэн байна.

2.2.5. “Мэдээллийн программ”-ыг ашиглан халдварт, паразит, зооноз, халдваргүй өвчин, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн мэдээг г графикт хугацаанд оруулж мэдээлсэн байна.

### **2.3. Хувийн Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ажлыг дүгэнэхдээ энэ журмын 2.1-д заасан үзүүлэлтээс гадна дор дурдсан шалгуурыг харгалзана Үүнд:**

2.3.1. Улсын болон малчид, үйлчлүүлэгчлүүлэгчдийн захиалгаар гүйцэтгэх халдварт, паразит өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хугацаанд 98-100 хувь биелүүлж, өвчний гарал, тархалтыг урьд оноос 50 хувиас доошгүй бууруулсан;

2.3.2. “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартын I, II зэрэглэлэлийн шаардлага хангасан;

2.3.3. Тухайн нэгжид ажиллаж буй малын эмч нь залуу халаагаа бэлтгэсэн, итгэмжлэгдсэн;

2.3.4. Харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга, Мал эмнэлгийн тасаг, малчинтай гурвалсан гэрээ байгуулж, хагас, бүтэн жилээр дүгнүүлсэн;

2.3.5. Өрхийн малын эрүүл мэндийн дэвтрийн хөтлөлтийн хөтөлгөөг тогтмолжуулсан;

2.3.6. Мал эмнэлгийн нэгжийг үүсгэн байгуулагч, нэгжийн эмч, гэрээт эмч нь тухайн орон нутагт тогтмол оршин суугч байна;

2.3.7. Мал эмнэлгийн үйлчилгээг хэвийн явуулах, шаардлагатай үед дайчлан ажиллуулах хүн хүч, техник хэрэгсэл, эмчилгээ, оношлогоо, угаалга, ариутгал, халдваргүйтгэлийн багаж, эмийн нөөц, бэлэн байдлыг хангасан байна;

2.3.8. Тухайн нэгжид ажиллаж байгаа малын эмч, туслах ажилтнуудыг эрүүл мэнд, нийгмийн даатгалд даатгуулсан, жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж бруцеллёз, сүрьеэ өвчний шинжилгээ хийлгэж өвчтэй тохиолдолд зохих арга хэмжээг авч шийдвэрлэсэн байна;

2.3.9. Энэхүү журмын 2.3.1.- 2.3.7-д заасан үзүүлэлтүүдийг харъяалах сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолтод тусгаж баталгаажуулсан байна.

2.3.10. Харилцагч банк, татвар, нийгмийн даатгалын байгууллагын өр, зээл, татвар, нийгмийн даалгалын авлагүйг тодорхойлсон албан тоот хавсрагасан байна.

## **ГУРАВ. ДҮГНЭХ ЖУРАМ**

3.1. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар энэхүү журмын 2.1., 2.2., 2.3.-т заасан тодорхойлолт, материалыг Мал эмнэлгийн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагад заасан хугацаанд бүрдүүлж ирүүлнэ.

3.1.1. Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын ажлыг Мал эмнэлгийн төв байгууллага өөрт байгаа мэдээллийг ашиглан байр эзлүүлж дүгэнэ;

3.1.2. Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар: сумын Мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг байр эзлүүлэн дүгнэж төвд явуулах тус бүр 1 (нэг) тасаг, нэгжийг шалгаруулан анкет, тодорхойлолт, бусад шаардагдах материалыг бүрдүүлэн тайлант оны дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор Мал эмнэлгийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад жил бүр ирүүлнэ.

3.2. Сумын Мал эмнэлгийн тасаг, хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж энэхүү журмын 2.1, 2.3-т заасан материалыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газарт жил бүрийн 12 дугаар сарын 01-нд багтаан ирүүлэх бөгөөд материалыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар нэгтгэн дүгнэж шалгаруулна.

3.2.1. Аймаг, нийслэлийн бүрдүүлж ирүүлсэн материалыг Мал эмнэлгийн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч ажлын хэсэг гаргаж дүгнэнэ.

Хугацаа хожимдуулсан тохиолдолд материалыг хүлээж авахгүй.

3.2.2. Ажлын хэсэг 3.1.1.-3.1.3-т заасан аймаг, нийслэлээс ирүүлсэн материалыг магадлан шалгаж, дүнг Мал эмнэлгийн газрын даргад танилцуулан, даргын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

3.2.3. Хамгийн өндөр оноо авсан аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар 3 (Гурав), сумын Мал эмнэлгийн тасаг 3 (Гурав), хувийн Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж 3 (Гурав), нийт 9 нэгжийн шалгаруулан тус бүрийг 1-3 дугаар дугаар байр эзлүүлэн Монгол улсын тэргүүний Мал эмнэлгийн газар, тасаг, нэгж цол, өргөмжлөл, урамшуулал олгоно.

## **ДӨРӨВ: УРАМШУУЛАЛ**

4.1. Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар:

1 дүгээр байр (нэг) 5,000,000.0 (Таван сая) төгрөг, өргөмжлөл

2 дүгээр байр (нэг) 2,500,000.0 (Хоёр сая таван зуун мянга) төгрөг, өргөмжлөл

3 дүгээр байр (нэг) 1,500,000.0 (Нэг сая таван зуун мянга) төгрөг, өргөмжлөл

4.2. Сумын Мал эмнэлгийн тасаг:

1 дүгээр байр (нэг) 5,000,000.0 (Таван сая) төгрөг, өргөмжлөл

2 дүгээр байр (нэг) 2,500,000.0 (Хоёр сая таван зуун мянга) төгрөг, өргөмжлөл

3 дүгээр байр (нэг) 1,500,000.0 (Нэг сая таван зуун мянга) төгрөг, өргөмжлөл

4.3. Хувийн Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж:

1 дүгээр байр (нэг) 10,000,000.0 (Арван сая) төгрөг, өргөмжлөл

2 дүгээр байр (нэг) 5,000,000.0 (Таван сая) төгрөг, өргөмжлөл

3 дүгээр байр (нэг) 3,000,000.0 (Гурван сая) төгрөг, өргөмжлөл

Нийт санхүүжилт жилд 36.0 сая төгрөг

----- о О о -----